



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 8551

Улаанбаатар хот

Сургалтад оролцуулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.11 дэх заалт, “Монголбанкны сургалтын журам”-ын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төлбөр тооцооны газрын захирал Э.Анар, мөн газрын Үндэсний цахим гүйлгээний төвийн захирал Б.Банзрагч, ахлах мэргэжилтэн Б.Галбаатар, програм хангамжийн инженер А.Түвшинбат, Я.Сайнсанаа, төлбөр тооцооны мэргэжилтэн Г.Галсандорж, мөн газрын Хяналт зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн А.Бат-Оргил, Төлбөрийн системийн шинэчлэл төслийн мэргэжилтэн Э.Эрхэмсүлд нарыг 2019 оны 10 дугаар сарын 13-наас 19-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл, Бүгд Найрамдах Сингапур Улсын Сингапур хотноо зохион байгуулагдах “Цахим төлбөрийн системийн хөгжил” сэдэвт сургалтад оролцуулсугай.

2.Дээрх нэр бүхий ажилтнуудын ирэх, очих онгоцны тийз, зочид буудал, дотоодын тээвэр болон болон томилолтын зардлыг Азийн хөгжлийн банкны “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн сургалтын зардлаас гаргахыг Төслийн удирдагч (Л.Баттөгөлдөр)-д зөвшөөрсүгэй.

3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т даалгасугай.

ТЭРГҮҮН ДЭД
ЕРӨНХИЙЛӨГЧ



О.ЭРДЭМБИЛЭГ